



**УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА, МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН
ТАНХИМЫН ДЭРГЭДЭХ МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН АРБИТРЫН
ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2021 оны 08 сарын 27 өдөр

Дугаар *A/19*

Улаанбаатар хот

Загвар батлах тухай

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.4 дэх хэсгийг үндэслэн, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.2.4, 87 дугаар зүйлийн 87.1.5, Арбитрын тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.2, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын Дэргэдэх Олон Улсын Арбитрын Төвийн Дүрмийн 2.4 дүгээр зүйлийн 2.4.2-т заасныг удирдлага болгон ТУШААХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.4 дэх заалтын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Монгол Улсын Их Хурлын /ээлжит, ээлжит бус, нөхөн/ сонгуульд нэр дэвшигчийн лавлагаа хүсэхдээ бүрдүүлэх бичиг баримтын жагсаалтыг нэгдүгээр, уг жагсаалтад дурдсан нэр дэвшигчийн лавлагаа хүсэх тухай өргөдлийн загварын маягтыг хоёрдугаар, зээл, барьцаа болон батлан даалтын талаар шүүхэд хариуцагчаар татагдан оролцож байсан эсэх мэдээллийг мэдүүлэх загварын маягтыг гуравдугаар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитраас авах лавлагааг хүсэх тухай өргөдлийн загварын маягтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Хамтарсан тушаалын хүрээнд мэдээллийг шуурхай солилцож, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүний туслах-ахлах шинжээч /М.Ганзориг/, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрын хуулийн мэргэжилтэн /П.Сугар/ нарт даалгасугай.

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА



С.АМАРДЭЛГЭР

МҮХАУТ-ЫН ДЭРГЭДЭХ
МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН
АРБИТРЫН ДАРГА



С.ЭНХЦЭЦЭГ

Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга,
МҮХАҮТ Дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрын
даргын 2021 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/19.....
дүгээр хамтарсан тушаалын хавсралт № 1.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧИЙН ЛАВЛАГАА
ХҮСЭХЭД БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.4,
29 дүгээр зүйлийн 29.3.1-д заасан лавлагааг 20... оны ... сарын ...-ны өдрөөс эхлэн
олгоно.

Лавлагаа хүсэхдээ дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

1. Иргэний үнэмлэхний хуулбар

2. Улсын Их Хурлын ээлжит, ээлжит бус, нөхөн /аль тохирохыг доогуур зурах/
сонгуулийн дугаар тойрогт нэр дэвшигчийн лавлагаа хүссэн өргөдөл.


/загвар №1/

3. Иргэний сүүлийн 10 жил байнга болон түр оршин суугаа газрын
тодорхойлолт.

4. Банк, бусад хуулийн этгээд, иргэнд төлбөл зохих зээл, барьцаа болон
батлан даалтын талаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль,
Арбитрын тухай хуульд заасны дагуу шүүх, арбитраг хариуцагчаар оролцож байсан
эсэх мэдээлэл.

/загвар №2, 3/

Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга,
МҮХАҮТ Дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрын
даргын 2021 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/19.....
дүгээр хамтарсан тушаалын хавсралт №2..



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД

20... оны ... сарын өдөр

Улаанбаатар хот

Лавлагаа хүсэх тухай



..... овогтой миний бие
Улсын Их Хурлын ээлжит, ээлжит бус, нөхөн сонгуулийн /аль тохирохыг доогуур зурах/
..... дугаар тойрогт /нам, эвсэл, бие даагчийн
аль тохирохыг доогуур зурах / нэр дэвшиж, холбогдох баримт бичгийг хуулийн дагуу
бүрдүүлсэн болно.

Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн
32.2.4-д заасан лавлагааг гаргаж өгнө үү.

Хүсэлт гаргасан:/

/

Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга,
МҮХАҮТ Дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрын
даргын 2021 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/19
дүгээр хамтарсан тушаалын хавсралт № 3..



Загвар №2

ЗЭЭЛ, БАРЬЦАА, БАТЛАН ДААЛТЫН ТАЛААР ШҮҮХЭД ХАРИУЦАГЧААР ТАТАГДАН ОРОЛЦОЖ БАЙСАН ЭСЭХ МЭДЭЭЛЭЛ

Банк, бусад хуулийн этгээд, иргэнд төлбөл зохих зээл, барьцаа, батлан даалтын талаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу шүүхэд хариуцагчаар оролцож байсан эсэх талаарх нэр дэвшигч
.....-ын мэдээлэл

1.Зээл, барьцаа, батлан даалтын үүрэгтэй холбоотой иргэний эрх зүйн маргаанд шүүхэд хариуцагчаар оролцож байсан эсэх

Тийм

Үгүй

Хэрэв тийм бол доорх хэсгийг бөглөнө үү?

2.Аль шүүхийн шүүн таслах ажиллагаанд хариуцагчаар татагдан оролцож байсан бэ?.....

3.Хэдэн онд

4.Тухайн маргаан эцэслэн шийдвэрлэгдсэн эсэх

Тийм

Үгүй

5.Тухайн хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн Шийдвэр, Магадлал, Тогтоолын огноо, дугаар

6.Шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолыг албадан гүйцэтгэх шүүхийн гүйцэтгэх хуудас бичигдэж, шүүгчийн захирамж гарсан эсэх

Тийм

Үгүй

Шүүгчийн захирамж болон гүйцэтгэх хуудасны огноо, дугаар

.....
.....

7.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дууссан эсэх.

Тийм



Үгүй

Мэдээллийг үнэн зөв гаргасан :/

/

20... оны сарын өдөр

Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга,
МҮХАҮТ Дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрын
даргын 2021 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/19
дүгээр хамтарсан тушаалын хавсралт № 4..



Загвар №3

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх
МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН АРБИРТ

20... оны сарын өдөр

Улаанбаатар хот

Улсын Их Хурлын ээлжит, ээлжит бус, нөхөн сонгуулийн /аль тохирохыг доогуур зурах/ дугаар тойрогт нэр дэвшигч би,

Регистрийн дугаар:	_____
Ургийн овог:	_____
Эцэг / эхийн нэр:	_____
Өөрийн нэр:	_____

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйл “Нэр дэвшүүлэх нийтлэг журам”-ын 29.3.1 “Нэр дэвшигч банк, бусад хуулийн этгээд, иргэнд шүүх болон арбитрын шийдвэрээр тогтоогдсон төлбөл зохих зээл, барьцаа болон батлан даалтын өр төлбөргүй байх” гэх шаардлагыг хангаж байгаа эсэхийг тодорхойлох хүсэлтэй байх тул миний бие тус арбитаар тогтоогдсон төлбөл зохих зээл, барьцаа болон батлан даалтын өр төлбөртэй эсэх талаарх лавлагаа гаргаж өгнө үү.

Уг лавлагааны хувийг Улсын Дээд Шүүх, Сонгуулийн Ерөнхий Хороонд хүргүүлэхийг миний бие үүгээр зөвшөөрч байна.

ХҮСЭЛТ ГАРГАСАН

/...../